



НИЯМАЗОН АУДИТ ХХК

МАТЕРИАЛ-ИМПЕКС ХК

---

САНХҮҮГИЙН ТАЙЛАН БОЛОН  
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 31

## БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

КОМПАНИЙН НЭР:	Материал-Импекс ХК	
ТУЗ-ИЙН ГИШҮҮД:	Дарга	Д.Оюун
	Ердийн гишүүд	Б.Зориг Б.Батбаатар Б.Болортуяа П.Баатарцэрэн Д.Төмөр-Очир
	Хараат бус гишүүд	Ц.Ариунаа Б.Саранцэцэг Ч.Энхтуул
УДИРДЛАГЫН БАГ:	Гүйцэтгэх захирал	Б.Зориг
	Санхүү эрхэлсэн захирал	П.Баатарцэрэн
	Ерөнхий нягтлан бодогч	Н.Мягмарсүрэн
	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Т.Лхагвачулуун
КОМПАНИЙН ХАЯГ:	Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 4 дүгээр хороо, Тээвэрчдийн гудамж, өөрийн байранд	
РЕГИСТРИЙН ДУГААР:	2074605	
ҮЙЛ АЖИЛЛАГАА:	Барилгын материалын худалдаа Бетон зуурмаг Орон сууц Хүнсний бөөний худалдаа Олон улсын тээвэр зуучлал Импортын тээвэр Вагоны тээвэр Гаалийн хяналтын бүс	
АЖИЛЛАГСДЫН ТОО:	84	
АУДИТОР:	Ниямазон аудит ХХК Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3 дугаар хороо, Чоймболын гудамж, Нийслэлийн үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны байр, 406 тоот	

## УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

Удирдлага нь санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу зохистой толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага дараах үүрэг хариуцлагыг биелүүлсэн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн зохих зарчмуудыг сонгож, тууштай мөрдөж, үндэслэл бүхий үнэлгээ, тооцоолол хэрэглэсэн;
- Компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн;
- Санхүүгийн тайланг үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлнэ гэсэн төсөөллийг баримтлан бэлтгэсэн.

Материал-Импекс ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Зориг болон ерөнхий нягтлан бодогч Н.Мягмарсүрэн бид 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал, энэ өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг мэдэгдэж байна.



Огноо: 2023.04.17

Ерөнхий нягтлан бодогч  
Н.Мягмарсүрэн

Огноо: 2023.04.17



МАТЕРИАЛ-ИМПЕКС ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

## NIYAMAZON AUDIT LLC

#408, Building of Trade Union Federation,  
Choimbol street, Chingeltei district,  
Ulaanbaatar 15172, Mongolia  
Tel: (976)70145906, (976) 91005906  
E-mail: audit@nmz.mn

№

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

#### Дүгнэлт

Бид Материал-Импекс ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусвар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Материал-Импекс ХК-ийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусвар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу үнэн, бодитой илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол Улсын Аудитын тухай хуулийн шаардлагын дагуу компаниас хараат бус байж бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

#### Санхүүгийн тайланд хүлээх удирдлагын үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу залилан болон алдаанаас улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэхэд шаардлагатай гэж тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага нь компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх ба нөлөөлөх асуудлыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

#### Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторовн үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторовн тайлан гаргах нь бидний зорилго юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан болон алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандаж, мэргэжлийн итгэл үнэмшил бүхий үнэлэлтийг хийдэг. Бид мөн:

- Залилан болон алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, тохирох аудитын горимыг боловсруулж, дүгнэлтийн үндэслэл болохуйц нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэгтэй холбоотой үүсдэг тул алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцоолуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Компанийн үйл ажиллагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд мөн багтдаг.

### Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг талуудын хооронд байгуулсан аудитын ажлын гэрээт захидалд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



З.Цээнээ  
Захирал  
Ниямазон аудит ХХК

Улаанбаатар хот, Монгол Улс  
2023 оны 04 дүгээр сарын 07


**МАТЕРИАЛ-ИМПЭКС ХК**  
**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**  
**2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар**

<i>Мянган төгрөгөөр</i>	<i>Тодруулга</i>	<b>2021 оны 12 дугаар сарын 31</b>	<b>2022 оны 12 дугаар сарын 31</b>
<b>ХӨРӨНГӨ</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3	4,794,842.8	9,506,829.8
Дансны авлага	4	16,954,831.3	16,680,973.6
Татвар, НДШ-ийн авлага	5	242,490.0	1,285,481.7
Бусад авлага	6	1,708,343.1	1,416,054.3
Бусад санхүүгийн хөрөнгө	7	14,000.0	14,000.0
Бараа материал	8	14,086,116.0	17,311,138.6
Урьдчилж төлсөн зардал тооцоо	9	9,316,271.0	14,008,184.7
Үндсэн хөрөнгө	10	3,729,573.2	3,885,220.5
Биет бус хөрөнгө	11	1,686.7	956.7
Урт хугацаат хөрөнгө оруулалт	12	184,471.6	184,471.6
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>51,032,625.7</b>	<b>64,293,311.5</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
Дансны өглөг	13	14,038,039.8	13,734,467.5
Цалингийн өглөг		51,205.9	77,514.8
Татварын өр	14	146,175.7	440,242.1
НДШ-ийн өглөг		19,122.5	-
Ногдол ашгийн өглөг		-	255,097.9
Урьдчилж орсон орлого		5,603,171.6	10,222,666.8
<b>Өр төлбөрийн дүн</b>		<b>19,857,715.5</b>	<b>24,729,989.1</b>
<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>			
Хувьцаат	19	136,820.6	136,820.6
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		3,133,970.5	3,133,970.5
Эздийн өмчийн бусад хэсэг		369,792.7	369,792.7
Хуримтлагдсан ашиг		27,534,326.4	35,922,738.6
<b>Эздийн өмчийн дүн</b>		<b>31,174,910.2</b>	<b>39,563,322.4</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>		<b>51,032,625.7</b>	<b>64,293,311.5</b>

Энэхүү санхүүгийн тайлангуудыг тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

**МАТЕРИАЛ-ИМПЭКС ХК**  
**ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**  
**2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар**

<i>Мянган төгрөгөөр</i>	Тодруулга	2021 оны 12 дугаар сарын 31	2022 оны 12 дугаар сарын 31
Борлуулалтын орлого	15	60,658,652.2	77,101,755.3
Борлуулалтын өртөг	16	50,355,974.6	70,021,088.5
<b>Нийт ашиг (алдагдал)</b>		<b>10,302,677.6</b>	<b>7,080,666.8</b>
Ногдол ашгийн орлого		-	2,779,838.9
Ерөнхий ба удирдлагын зардал	17	4,590,633.4	4,487,958.6
Бусад зардал	18	6,260.1	136,263.7
Гадаад валютын ханшийн зөрүүгийн өлз (гарз)		21,917.4	4,021,779.2
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>5,727,701.5</b>	<b>9,258,062.6</b>
Орлогын татварын зардал		574,486.3	554,963.0
<b>Цэвэр ашиг (алдагдал)</b>		<b>5,153,215.2</b>	<b>8,703,099.6</b>



Энэхүү санхүүгийн тайлангуудыг тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

**МАТЕРИАЛ-НМЦГЭС ХК**  
**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**  
**2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар**

<i>Мянган төгрөгөөр</i>	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>136,820.6</b>	<b>3,133,970.5</b>	<b>369,792.7</b>	<b>22,381,111.2</b>	<b>26,021,695.0</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	136,820.6	3,133,970.5	369,792.7	22,381,111.2	<b>26,021,695.0</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	5,153,215.2	<b>5,153,215.2</b>
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>136,820.6</b>	<b>3,133,970.5</b>	<b>369,792.7</b>	<b>27,534,326.4</b>	<b>31,174,910.2</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	136,820.6	3,133,970.5	369,792.7	27,534,326.4	<b>31,174,910.2</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	8,703,099.6	<b>8,703,099.6</b>
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	314,687.4	<b>314,687.4</b>
<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>136,820.6</b>	<b>3,133,970.5</b>	<b>369,792.7</b>	<b>35,922,738.6</b>	<b>39,563,322.4</b>


Энэхүү санхүүгийн тайлангуудыг тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.



**МАТЕРИАЛ-ИМПЭКС ХК**  
**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
**2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2021 оны 12 дугаар сарын 31</b>	<b>2022 оны 12 дугаар сарын 31</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	25,033,210.4	69,514,088.4
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	3,718.0
Бусад мөнгөн орлого	10,831.7	86,194.1
Ажиллагчдад төлсөн	867,634.2	1,293,621.6
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	222,000.0	422,100.0
Бараа материал худалдан авахад төлсөн	10,951,869.3	51,470,210.0
Ашиглалтын зардалд төлсөн	9,369.0	88,045.2
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	29,092.5	88,129.4
Хүүний төлбөрт төлсөн	1,210.9	280.0
Татварын байгууллагад төлсөн	1,996,432.0	1,860,271.3
Даатгалын төлбөрт төлсөн	3,198.1	24,631.8
Бусад мөнгөн зарлага	7,154,315.5	8,962,254.3
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>3,808,920.6</b>	<b>5,394,456.9</b>
Хүлээн авсан ногдол ашиг	-	4.6
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	20,249.7	48,791.3
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	700.0	-
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(20,949.7)</b>	<b>(48,786.7)</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	15,110,010.9	25,000,000.0
Бусад орлого	5,600.5	340,062.4
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	15,468,355.3	25,904,938.1
Төлсөн ногдол ашиг	-	41,712.2
Бусад зарлага	13,312.2	27,095.3
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(366,056.1)</b>	<b>(633,683.2)</b>
<b>БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>3,421,914.8</b>	<b>4,711,987.0</b>
<b>МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	<b>1,372,928.0</b>	<b>4,794,842.8</b>
<b>МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>4,794,842.8</b>	<b>9,506,829.8</b>

Энэхүү санхүүгийн тайлангуудыг тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.



## 1. ТАНИЛЦУУЛГА

Тус байгууллага нь гадаад орноос болон дотоодын үйлдвэрүүдийн материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг хүлээн авах, хадгалах, хэрэглэгч байгууллагуудад нийлүүлэх буюу барилгын материалын хангалтыг нэгдсэн журмаар бэлтгэн нийлүүлэх үүрэгтэйгээр 1957 онд анх байгуулагдаж, 1999 оноос хувьцаат компанийн статусаар үйл ажиллагаа явуулж байна.

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа:

- Барилга хот, байгуулалтын яамнаас олгосон БА-4.1, БА-6.1, БА-6.2, БА-6.3, БА-6.4 заалтын дагуу ажил, үйлчилгээ эрхлэх, 2027 оны 05 дугаар сарын 09 хүртэл хүчинтэй;
- Материалын үйлдвэрлэл 4.2 заалтын дагуу 2022 оны 07 дугаар сарын 22 хүртэл хүчинтэй;
- Зам, тээврийн хөгжлийн яамнаас олгосон төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаа эрхлэх, 2025 оны 03 дугаар сарын 21 хүртэл хүчинтэй.

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Материал-Импэкс ХК-ийн Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан заавар, маягтын дагуу бэлтгэгдсэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангуудаас бүрдэнэ.

*Бид аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, Монгол Улсад мөрдөж буй аудитын хууль тогтоомжийг баримтлан ажилласан. Аудитын дүгнэлт гаргахдаа тус компаниас бидэнд танилцуулсан санхүүгийн баримт, материалд үндэслэсэн болно. Аудитын явцад бидэнд танилцуулаагүй аливаа баримт материалаас үүсэх хариуцлагыг манай аудитын байгууллага хүлээхгүй юм.*

### 2.1 Санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь

Компанийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу түүхэн өртгөөр бүртгэх тогтсон зарчмыг баримтлан аккруэл сууриар бэлтгэгдсэн ба Компани өөрийн санхүүгийн байдлын тайланг хөрвөх чадварын дарааллаар толилуулдаг.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг дор толилуулав. Өөрөөр заагаагүй санхүүгийн тайлагналын хугацааны туршид эдгээр бодлогыг тогтмол баримталдаг.

### 2.2 Санхүүгийн тайланг бэлтгэсэн байдал

Компани нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэхдээ “Интерактив Диамонд 5.0” програм ашиглан гаргадаг. Санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан гэсэн үндсэн 4 тайлан, санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгаас бүрдсэн байна.

### 2.3 Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

Компанийн үйл ажиллагаа цаашид хэвийн үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн, тасралтгүй үйл ажиллагааны зарчмаар санхүүгийн тайлангаа бэлтгэсэн. Дээрх тасралтгүй үйл ажиллагааны талаарх төсөөлөл нь үр дүн нь тодорхойгүй байгаа ирээдүйд болж болох үйл явцад суурилсан болно.

### 2.4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд түргэн хөрвөх боломжтой, үнэ цэнээ алдах эрсдэл багатай хэрэгсэл хамаарна. Касс болон банкны харилцах дансанд байгаа мөнгө, хугацаагүй хадгаламж, 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарласан тусгай зориулалт бүхий мөнгөн сан, үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацаатай хөрөнгө оруулалт хамаарна. Эдгээр хөрөнгийг нэрлэсэн үнээр бүртгэнэ.

## 2.5 Авлага

*Дансны авлага*-Аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах авлагын дүн орно. Дансны авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр нь тусгана.

*Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага*-Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, бусад татвар хураамжийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцсээрх илүү төлөгдсөн дүн орно. Улирал ба жилийн эцэс дэх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын дүн нь татвар, нийгмийн даатгалын байгууллагын баталгаажуулсан дүнтэй тэнцүү байна.

## 2.6 Бараа материал

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө, үйлдвэрлэлийн дамжлагад байгаа зүйлс болон үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэх материал, хангамжийн зүйлс хамаарна.

## 2.7 Урьдчилж төлсөн зардал, тооцоо

Тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зарлагыг (даатгал, түрээс г.м) санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн зүйл ангид хамааруулж, урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ. Ийм төрлийн зарлагыг дараагийн тайлант үеийн холбогдох зардалд нь шингээнэ. Бараа материал, бусад зүйлсийг худалдан авахаар төлсөн урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоонд хамааруулна.

## 2.8 Үндсэн хөрөнгө

Тайлант хугацаа бүрийн эцэст үндсэн хөрөнгө ба тоног төхөөрөмжийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл, хорогдол болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тусгадаг. Хөрөнгийг олж эзэмшихтэй холбоотой гарсан зардлыг өртөгт шингээнэ. Худалдан авсан тоног төхөөрөмжийн ажиллагааны салшгүй хэсэг болох программ хангамжийг холбогдох тоног төхөөрөмжийн хамт капиталжуулна.

*Үндсэн хөрөнгийн элэгдэл*-Хөрөнгийн өртгийг доорх хүлээгдэж буй ашиглах хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан элэгдүүлнэ.

*Биет бус хөрөнгө*-Биет бус хөрөнгө гэж биет шинж чанаргүй, тодорхойлж болохуйц, мөнгөн бус хөрөнгийг хэлнэ. Санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдол, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дансны цэвэр дүнгээр нь толилуулна.

## 2.9 Өр төлбөр

*Дансны өглөг*-Бизнесийн үндсэн үйл ажиллагааны явцад бэлтгэн нийлүүлэгчдээс худалдан авсан бараа, хангамжийн зүйлс, үйлчилгээний үнийн төлөгдөөгүй үлдэгдэл хамаарна.

*Татварын өр*- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ), онцгой албан татвар (ОАТ)-ын өр, бусад татвар, төлбөр, хураамжийн тайлант хугацааны эцэст төлөгдөөгүй үлдэгдэл хамаарна. Улирал ба жилийн эцэс дэх төлөгдөөгүй татварын үлдэгдэл нь татварын байгууллагаас баталгаажуулсан үлдэгдэлтэй тэнцүү байна.

*Богино хугацаат зээл, хүүгийн өглөг*- Нэг жилээс доош хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын эх үүсвэр, холбоотой талаас авсан зээлийн дүнг энэ хэсэгт толилуулна.

*Урьдчилж орсон орлого*-Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ үзүүлэхээс өмнө тэдгээрийн үнийг худалдан авагч эсхүл захиалагчаас урьдчилан хүлээн авсан тохиолдолд хүлээн авсан мөнгөний хэмжээгээр богино хугацаат өр үүсгэж энэ дансанд бүртгэнэ.

## 2.10 Дүрмийн сан

Аж ахуйн нэгжийн өр төлбөрөө төлсний дараагаар үлдэх цэвэр хөрөнгийн хэмжээг эздийн өмч гэж үзнэ. Энгийн хувьцааг дүрмийн сангаар бүртгэнэ.

Хуримтлагдсан ашиг-Компанийн үүсэн байгуулагдсанаас хойшхи хугацаанд компанид хуримтлагдан үлдсэн ашиг, алдагдлын нийлбэрийг хуримтлагдсан ашиг дансанд бүртгэнэ.

## 2.11 Орлого

Тайлангийн хугацаанд худалдсан бараа, бүтээгдэхүүн буюу гадагш үзүүлсэн ажил, үйлчилгээний орлого зэрэг байнгын, тогтмол үйл ажиллагаанаас олсон орлогыг борлуулалтын хөнгөлөлт, буцаалт болон үнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр нь орлогын дэлгэрэнгүй тайланд тусгана.

## 2.12 Татвар

ААНОАТ-Тус компанийн үйл ажиллагаа нь тайлант хугацаанд СТОУС-ын дагуу санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлсон татварын өмнөх ашгийг Монгол Улсын Аж ахуй нэгжийн орлогын албан татварын хууль түүнд нийцүүлж гаргасан заавар, журмын дагуу татвараас чөлөөлөгдөх орлого болон татвар ногдуулах орлогоос хасагдахгүй зардлын зүйлсээр залруулан орлогын албан татварыг тодорхойлдог.

**МАТЕРИАЛ-НМИГЭС ХК**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**  
**2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар**

**3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ**

Ангилал	(мян.төг)	
	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
Бэлэн мөнгө		
Кассанд байгаа бэлэн мөнгө	73,350.0	117,848.2
Кассанд байгаа бэлэн доллар	376,617.5	679,850.7
Кассанд байгаа бэлэн юань	3,150.8	1,758.4
Кассанд байгаа бэлэн рубль	464.3	5,578.7
<b>Дүн</b>	<b>453,582.6</b>	<b>805,036.0</b>
Банкин дахь харилцах		
Төрийн банк /төгрөг/	5,038.3	41.5
Төрийн банк /доллар/	26.0	7.6
Төрийн банк /юань/	3.4	3.8
Хаан банк /төгрөг/	446,669.7	3,101,008.0
Хаан банк /төгрөг/	133,751.1	3,233.6
Хаан банк /доллар/	2,957,891.4	4,591,393.7
Хаан банк /юань/	-	1,980.5
Хаан банк /рубль/	573.2	3,935.1
Худалдаа хөгжил /төгрөг/	302,578.6	8,674.5
Худалдаа хөгжил /доллар/	17,605.8	24,281.6
Хас банк /төгрөг/	39,632.9	21,966.6
Хас банк /доллар/	4,282.7	18,501.6
Голомт банк /төгрөг/	377,667.7	15,279.8
Голомт банк /төгрөг/	1.0	1.0
Голомт банк /доллар/	54,916.5	873,594.8
Голомт банк /юань/	35.9	33,594.8
Голомт банк /евро/	155.3	3,847.3
Голомт банк /рубль/	14.5	5.5
ХХБанк /төгрөг/	12.3	0.3
ХХБанк /төгрөг/ хадгаламж	22.6	10.6
ХХБанк /доллар/	170.3	192.8
ХХБанк /юань/	32.1	35.6
Харилцах /төгрөг/	19.0	19.0
Харилцах /төгрөг/	43.0	43.0
Харилцах /доллар/	116.9	141.2
<b>Дүн</b>	<b>4,341,260.2</b>	<b>8,701,793.8</b>
<b>Нийт дүн</b>	<b>4,794,842.8</b>	<b>9,506,829.8</b>

**4. ДАНСНЫ АВЛАГА**

Ангилал	(мян.төг)	
	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
Байгууллагаас авах	13,336,792.8	10,857,351.3
Агуулахын түрээсийн	67,968.6	78,755.8
Оффисын түрээсийн	19,996.0	11,433.5
Дамжин өнгөрөх түрээсийн	3,951.7	1,369.0
Тээврийн хөлсний	19,035.4	11,585.8
Вагон таталт, тавилтын	11,169.1	2,667.6

**МАТЕРИАЛ-ИМПЭКС ХК**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

**2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар**

Зам талбайн ашиглалтын	3,946.0	2,147.0
Дотоод үйлчилгээний	16,505.0	11,529.1
Талбайн үйлчилгээний	66,488.6	85,128.0
УБ өргөөнөөс авах	31,052.6	27,274.1
Контейнер тээврийн	2,845,565.9	5,500,398.9
Хүмүүсээс авах	532,359.5	91,333.5
Нийт дүн	<b>16,954,831.2</b>	<b>16,680,973.6</b>

**5. ТАТВАРЫН АВЛАГА**

Ангилал	(мян.төг)	
	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
НӨАТ-ын авлага	235,377.0	1,277,653.8
НДШ-ийн авлага	-	714.9
ХХОАТ-н авлага	1,428.3	1,428.3
ҮХЭХАТ-н авлага	5,684.7	5,684.7
Нийт дүн	<b>242,490.0</b>	<b>1,285,481.7</b>

**6. БУСАД БОГИНО ХУГАЦААТ АВЛАГА**

Ангилал	(мян.төг)	
	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
Ажиллагчдаас авах авлага	1,078,906.2	1,173,046.0
Бусад талуудаас авах авлага	629,436.9	243,008.3
Нийт дүн	<b>1,708,343.1</b>	<b>1,416,054.3</b>

**7. БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ**

Ангилал	(мян.төг)	
	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
Үндэсний тээврийн корпораци	14,000.0	14,000.0
Нийт дүн	<b>14,000.0</b>	<b>14,000.0</b>

**МАТЕРИАЛ-ИМПЭКС ХК**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

**2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар**

**8. БАРАА МАТЕРИАЛ**

(мян.төг)

Ангилал	Түүхий эд материал	Дуусаагүй үйлдвэрлэл	Бараа	Хангамжийн материал	Нийт дүн
2022 оны 1 сарын 1	157,531.2	49,660.60	13,632,136.9	246,787.30	<b>14,086,116.0</b>
Нэмэгдсэн	930,315.0	-	49,533,117.9	364,144.30	<b>50,827,577.2</b>
Хасагдсан	839,763.0	-	46,581,142.0	181,649.60	<b>47,602,554.6</b>
2022 оны 12 сарын 31	<b>248,083.2</b>	<b>49,660.6</b>	<b>16,584,112.80</b>	<b>429,282.0</b>	<b>17,311,138.6</b>

**9. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ТООЦОО**

(мян.төг)

Ангилал	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
Үйлчилгээний төв	1,355,860.2	828,144.4
Үндсэн хөрөнгө	158,530.3	1,540.1
Лифт	205,878.2	205,878.2
Тээвэр	685,206.5	685,206.5
Зогсоол	6,831,527.7	12,157,524.6
Дахин төлөвлөлт	31,413.8	31,413.8
Бусад	47,854.3	98,477.1
Нийт дүн	<b>9,316,271.0</b>	<b>14,008,184.7</b>

**МАТЕРИАЛ-ИМПЭКС ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

**2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар**

**10. ҮНДСЭН ХӨРӨНГӨ**

(мян.төг)

Ангилал	Барилга, байгууламж	Машиин, тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер бусад хэрэгсэл	Бусад үндсэн хөрөнгө	Нийт дүн
<b>Анхны өртөг</b>							
2022 оны 1 сарын 1	5,823,947.0	212,529.1	1,320,456.4	62,226.3	50,752.0	42,636.8	7,512,547.6
Нэмэгдсэн	230,193.3	-	328,465.5	29,177.8	34,261.4	-	622,098.0
Хасагдсан	-	-	-	-	-	-	-
2022 оны 12 сарын 31	<b>6,054,140.3</b>	<b>212,529.1</b>	<b>1,648,921.9</b>	<b>91,404.1</b>	<b>85,013.4</b>	<b>42,636.8</b>	<b>8,134,645.6</b>
<b>Хуримтлагдсан элэгдэл</b>							
2022 оны 1 сарын 1	2,555,703.9	185,737.3	923,376.7	57,270.2	41,608.9	19,277.5	3,782,974.5
Тайлант онд байгуулсан элэгдэл	276,926.2	8,407.0	155,087.6	3,312.9	12,904.7	9,812.2	466,450.6
Хасагдсан	-	-	-	-	-	-	-
2022 оны 12 сарын 31	<b>2,832,630.1</b>	<b>194,144.3</b>	<b>1,078,464.3</b>	<b>60,583.1</b>	<b>54,513.6</b>	<b>29,089.7</b>	<b>4,249,425.1</b>
<b>Дансны үнэ</b>	<b>3,221,510.2</b>	<b>18,384.8</b>	<b>570,457.6</b>	<b>30,821.0</b>	<b>30,499.8</b>	<b>13,547.1</b>	<b>3,885,220.5</b>

**11. БИЕТ БУС ХӨРӨНГӨ**

(мян.төг)

Ангилал	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
Компьютерийн программ хангамж	6,600.0	7,300.0
Нэмэгдсэн дүн	700.0	-
2022 оны 12 сарын 31	<b>7,300.0</b>	<b>7,300.0</b>
<b>Хуримтлагдсан хорогдол</b>		
Эхний үлдэгдэл	4,930.0	5,613.3
Байгуулсан хорогдол	683.3	730.0
2022 оны 12 сарын 31	<b>5,613.3</b>	<b>6,343.3</b>
<b>Дансны үнэ</b>	<b>1,686.7</b>	<b>956.7</b>



**МАТЕРИАЛ-НМПГЭС ХК**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**  
**2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар**

**12. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**

Ангилал	(мян.төг)	
	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
Хөрөнгө оруулалт МИК ХХК	123,427.9	123,427.9
Хөрөнгө оруулалт бусад	61,043.7	61,043.7
Нийт дүн	<u>184,471.6</u>	<u>184,471.6</u>

**13. ДАНСНЫ ӨГЛӨГ**

Ангилал	(мян.төг)	
	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
Төлөгдөх хугацаандаа байгаа	14,038,039.8	13,734,467.5
Нийт дүн	<u>14,038,039.8</u>	<u>13,734,467.5</u>

**14. ТАТВАРЫН ӨР**

Ангилал	(мян.төг)	
	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
ААНОАТ	56,665.3	383,731.9
НӨАТ	66,243.3	356.4
ХХОАТ	23,267.1	56,149.9
Бусад татвар	-	3.9
Нийт дүн	<u>146,175.7</u>	<u>440,242.1</u>

**15. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО**

Ангилал	(мян.төг)	
	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
Барилгын материал, арматур, цемент борлуулалт	37,941,429.5	39,188,863.9
Хүнсний материал борлуулалт	11,975,493.3	9,251,228.7
Бусад бараа борлуулалт	6,353,102.8	4,745,436.1
Контейнерийн	3,310,917.6	21,558,357.2
Дотоод үйлчилгээний	115,593.8	1,054,313.9
Зам талбай ашиглалтын	42,945.6	65,840.8
Талбай, краны үйлчилгээний	428,654.9	470,964.5
Түрээсийн	461,180.7	717,502.7
Бусад	29,334.0	49,247.5
Нийт дүн	<u>60,658,652.2</u>	<u>77,101,755.3</u>

**МАТЕРИАЛ-ИМПЭКС ХК**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

**16. БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ**

Ангилал	(мян.төг)	
	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	46,102,392.2	48,272,673.0
Үзүүлсэн үйлчилгээний өртөг	4,253,582.4	21,748,415.5
<b>Нийт дүн</b>	<b>50,355,974.6</b>	<b>70,021,088.5</b>

**17. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ**

Ангилал	(мян.төг)	
	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
Ажиллагчдын цалин	1,074,149.7	1,600,286.4
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ	123,661.8	217,586.0
Албан татвар, төлбөр, хураамжийн	19,248.2	19,863.3
Томилот	-	8,317.2
Бичиг хэргийн	7,672.8	7,268.1
Шуудан холбоо	23,887.3	17,746.4
Сургалт	2,890.0	1,410.0
Даатгал	3,198.1	24,631.8
Ашиглалтын	10,900.8	103,000.7
Засвар	154,848.2	201,105.0
Элэгдэл, хорогдлын	380,662.9	467,180.7
Цэвэрлэгээ үйлчилгээ	16,880.2	15,879.8
Шатахуун	29,073.3	66,307.6
Зар сурталчилгаа	381.1	11,723.8
Зээлийн хүү	358,344.3	904,938.1
Хөдөлмөр хамгаалал	31,463.4	42,729.1
Бусад	2,353,371.3	777,984.6
<b>Нийт дүн</b>	<b>4,590,633.4</b>	<b>4,487,958.6</b>

**18. БУСАД ЗАРДАЛ**

Ангилал	(мян.төг)	
	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
Алданги, торгууль	1,210.9	280.0
Хандив	3,350.0	84,239.3
Үйл ажиллагааны бус бусад	1,699.2	51,744.4
<b>Нийт дүн</b>	<b>6,260.1</b>	<b>136,263.7</b>

**19. ХУВЬЦАА**

Хувьцаа эзэмшигч	Эзэмшиж буй хувь	Хувьцааны тоо
Д.Тунгалаг	7.25	99,192
З.Тогос	10.54	144,272
З.Цолмон	11.36	155,468
Б.Зориг	56.17	768,564
Бусад	14.68	200,710
<b>Нийт дүн</b>	<b>100.00</b>	<b>1,368,206</b>

Хувьцаа эзэмшигчийн тоо: 1478

## **20. ХОЛБООТОЙ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ**

Тайлант хугацаанд холбоотой талуудтай гүйлгээ хийсэн ба эдгээр нь санхүүгийн тайланд тусгагдсан, зохих тодруулга хийгдсэн.

## **21. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР**

Тус компанид 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар болзошгүй өр төлбөр байхгүй байна.

## **22. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВЦ**

Материал-Импэкс ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан гарснаас хойш санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхүйц үйл явдал гараагүй байна.

## **23. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ ТУХАЙ**

Тус компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй холбоо бүхий тайланд нөлөө үзүүлэхүйц үйл явдал гараагүй байна.